

“МОНГОЛ УЛСАД ЭХ, ХҮҮХЭД, НЯРАЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Төслийн мэдээлэл

Төслийн зорилго:

Монгол Улсад ургийн гаж хөгжлийг эрт оношилж, нярайн мэс заслын тусламж, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний хүртээмж, эх, нярай, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:

- Эх, эмэгтэйчүүдийн мэс засалд орчин үеийн шинэ технологи нэвтрүүлж, ургийн гаж хөгжлийн оношилгоог шинэ шатанд хүргэх;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шинэ технологийг нэвтрүүлснээр ураг, нярайн мэс заслын тусламжийг сайжруулж, нутагшуулах;
- Хүүхдэд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний хүртээмжийг сайжруулах.

Төслийн хэрэгжих хугацаа: 3 жил

Төслийн байршил: Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.2.16. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна;
- 2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ;
- 2.3.1. Хүн амын төрөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин:

- 1.2. Хорт хавдраар нас барсан 100,000 хүнд ноогдох тоог 2030 он гэхэд 8.0 болгон бууруулах зорилт.

Хоёр. Төслийн санхүүжилт, нөхцөл

Төслийн хүрээнд худалдан авах тоног төхөөрөмж:

| № | Тоног төхөөрөмжийн нэр | Багцын үнэ |
|----------|--|-------------------|
| 1 | Эх, хүүхэд нярайн яаралтай мэс заслын тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл | 3,492,118.03 |

| | | |
|-------------|---|---------------------|
| 2 | Хүүхдийн сэргээн засах тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж | 323,572.84 |
| 3 | Мэс заслын хувцас хэрэгсэл угаах угаалгын тоног төхөөрөмж | 301,826.70 |
| 4 | Дүрс оношлогооны тоног төхөөрөмж | 2,744,730.68 |
| 5 | Нярайн эрчимт эмчилгээний тоног төхөөрөмж | 281,030.44 |
| 6 | Ясны чөмөг шилжүүлэн суулгахад хэрэглэгдэх тоног төхөөрөмж, хэрэгсэл | 610,819.67 |
| 7 | Хүүхэд, нярайн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын ажлын байрны, онол, дадлага хосолсон сургалт | 245,901.64 |
| НИЙТ | | 8,000,000.00 |

Гурав. Төслийн хүрээнд хийгдэх ажил, үр дүн

Энэхүү төсөл амжилттай хэрэгжсэнээр дараах үр дүнгүүд гарахаар хүлээгдэж байна:

- Ургийн гаж хөгжлийн оношилгоо шинэ шатанд хүрсэн байна;
- Ураг, нярайн мэс заслын тусламж сайжирч, нутагшсан байна;
- Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний хүртээмж сайжирна;
- 0-5 насны хүүхдийн өвчлөл, эндэгдэл буурна;
- Эмнэлгийн ажилтнуудын мэдлэг, чадвар дээшилнэ;
- Хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ бий болно.

---oOo---